



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 22 өдөр

Дугаар А/317

Чингис хот

Тусгай зөвшөөрөл сунгах, зарим байгууллагын
гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.5-ын "г", Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 10 дугаар зүйлийн 10.1.5, 16 дугаар зүйлийн 16.2.2, Эрүүл мэндийн сайдын 2015 оны журам батлах тухай 298 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт "Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын ажиллах журам"-ын 2 дугаар хэсгийн 2.6.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 53 дугаар тогтоолын 5.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Sun med" сэтгэц наркологийн клиник, Ахуйн шавьж, мэрэгч устгах халдваргүйжүүлэлтийн байгууллага, "Эрдэнэ тун" эмийн сан, Өмнөдэлгэр суманд үйл ажиллагаа явуулж буй "Өргөжих" хүүхэд, дотрын клиник, "Од мандах" эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус 3 жилээр, Баян-Овоо суманд үйл ажиллагаа явуулж буй "Алтан талын хишиг" эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хугацааг 1 жилээр тус тус сунгасугай.

2. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Оточ Сэрвэн ХХК"-ний дүрс оношилгооны клиникийн "Гурван Эрдэнэ" нэрийг "Оточ гурван эрдэнэ" нэрээр өөрчилсүгэй.

3. Хэрлэн суманд үйл ажиллагаа явуулж буй "Монос Хэнтий" эм ханган нийлүүлэх байгууллага, "Эм Эрдэнэ" эмийн сангийн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд мансууруулах, сэтгэц нөлөөт эмийг ханган нийлүүлэх, худалдаалах зөвшөөрлийг нэмэлтээр оруулсугай.

2.

4. Дээрх эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА